



САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2023 оны 04 сарын 21 өдөр

Дугаар 136

Улаанбаатар хот

Итгэлцлийн үйлчилгээ эрхлэх банк бус санхүүгийн байгууллагын хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээ, үе шаттай нэмэгдүүлэх хуваарь батлах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2, Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2 дахь хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:


1. Банк бус санхүүгийн итгэлцлийн үйлчилгээ эрхлэх хуулийн этгээдийн хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээг Улаанбаатар хотод 5,000,000,000 (таван тэрбум) төгрөг, Орхон аймгийн Баян-Өндөр, Дархан-Уул аймгийн Дархан сумдад 1,200,000,000 (нэг тэрбум хоёр зуун сая) төгрөг, бусад аймаг, сумдад 400,000,000 (дөрвөн зуун сая) төгрөг байхаар тус тус тогтоосугай.

2. Банк бус санхүүгийн итгэлцлийн үйлчилгээ эрхэлж буй банк бус санхүүгийн байгууллагуудын хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээг үе шаттай нэмэгдүүлэх хуваарийг хавсралтаар баталсугай.

3. Энэхүү тогтоолыг баталсантай холбогдуулан Санхүүгийн зохицуулах хорооны 2019 оны 441 дүгээр тогтоолын 4 дэх заалтыг хүчингүй болсонд тооцсугай.

4. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба (Т.Жамбаажамц)-нд даалгасугай.

ДАРГА



Д.БАЯРСАЙХАН

Санхүүгийн зохицуулах хорооны 2023
оны 04 дүгээр сарын 21-ний өдрийн
136 дугаар тогтоолын хавсралт



ИТГЭЛЦЛИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛТЭЙ БАНК БУС
САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН ХУВЬ НИЙЛҮҮЛСЭН ХӨРӨНГИЙН
ДООД ХЭМЖЭЭГ ҮЕ ШАТТАЙ НЭМЭГДҮҮЛЭХ ХУВААРЬ

(сая төгрөгөөр)

Огноо	Улаанбаатар хот
2024.02.10	3,500.0
2025.02.10	4,200.0
2026.02.10	5,000.0